



ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A/26

Улаанбаатар хот

Монгол улсын хилээр геологи, эрдэс баялгийн суурь болон сэдэвчилсэн судалгааны дээж (сорьц) нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох заавар батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн ерөнхий газрын Гаалийн хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын хилээр геологи, эрдэс баялгийн суурь болон сэдэвчилсэн судалгааны дээж (сорьц) нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох түр зааврыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалаар батлагдсан зааврыг хэрэгжүүлэн ажиллахыг Дэд дарга буюу ерөнхий геологич (Б.Уянга), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (С.Шинэ-Од) нарт тус тус үүрэг болгосугай.



ДАРГА

О.ЧУЛУУН

**Монгол улсын хилээр геологи, эрдэс баялгийн
суурь болон сэдэвчилсэн судалгааны
дээж (сорьц) нэвтрүүлэхэд тодорхойлолт
олгох түр заавар**

Нэг: Ерөнхий зүйл

- 1.1. Монгол Улсын “Ашигт малтмалын тухай” хуулийн 16, 11, 11¹ дүгээр зүйл, “Газрын хэвлийн тухай” хуулийн 12, 22, 48, 51 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, “Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь хэсэг, Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 362 дугаар тушаалаар баталсан “Улсын хилээр нэвтрүүлэх онцлог бараанд гаалийн бүрдүүлэлт хийх журам”-ыг хэрэгжүүлэхэд оршино.
- 1.2. Геологи, эрдэс баялгийн холбогдолтой суурь болон сэдэвчилсэн судалгаа, шинжилгээний бүтээл, холбогдох зураг, мэдээлэл, бүх төрлийн чулуун дээж (сорьц)-ийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоход энэ журмыг баримтална.
- 1.3. Геологи, эрдэс баялгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /Үндэсний Геологийн Алба/-ын тухайн чиглэлийг хариуцсан /нэгжийн/ дарга гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарагдсан зөвшөөрлийг /тодорхойлолтыг/ хүчин төгөлдөрт тооцох бөгөөд эдгээр албан тушаалтан нь олгосон зөвшөөрөл /тодорхойлолт/-ийн хариуцлагыг бүрэн хүлээнэ.
- 1.4. Улсын хилээр дээж (сорьц) гаргах зөвшөөрөл /тодорхойлолт/ хүссэн этгээд нь Монгол Улсад албан ёсны бүртгэлтэй, геологи, эрдэс баялгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа шинжилгээ, боловсруулалт хийх эрх бүхий байгууллага, хуулийн этгээд байна.

Хоёр: Дээж (сорьц), түүний төрөл

Геологи, эрэл, үнэлгээ, эрдэс баялгийн судалгааны бүх төрлийн үе шатны ажлын явцад лабораторийн шинжилгээ, судалгааны зориулалтаар авч гадаад орнуудад лабораторийн болон судалгаа, шинжилгээ хийх зорилго бүхий эрдэс баялгийн дээж (сорьц), дагалдах материалыг “хилээр нэвтрүүлэх шинжилгээний дээж (сорьц)” гэнэ.


- 2.1. Региональ геологи, эрэл-үнэлгээ, болон лабораторийн хяналт-шинжилгээ зэрэг үйл ажиллагаатай уялдуулан дээж (сорьц)-ийн төрөл, жинг тогтооно / Хүснэгт №1/.
- 2.2. Гадаад оронд шинжилгээ, судалгаа хийлгэхээр бэлтгэсэн дээж (сорьц)-д шаардлагатай гэж үзвэл Геологийн төв лаборатори болон магадлан итгэмжлэгдсэн бусад лабораториор хяналт, шалгалтын шинжилгээ хийлгэнэ.
- 2.3. Түр зааврын дагалдах нэг, хоёрдугаар маягтыг зохих зааврын дагуу, үнэн зөв бүрдүүлсэн байна. / Маягт 1, Маягт 2 /

№	Шинжилгээний төрөл	Дээж (сорьц)-ийн төрөл	Жин /кг/	Тайлбар
1	Геологийн суурь болон эрдэс баялгийн хэтийн төлөв тодорхойлох судалгааны үе шатад геохими, эрдэс, гэрэл, петрографи, минерографийн шинжилгээний дээж (сорьц) болон инженер геологи, геотехникийн судалгаа шинжилгээний хөрсний дээж (сорьц)	Чулуун дээж	5 /нэг дээжийн жин/	-Чулуулаг болон хүдрийн төрлөөс хамаарахгүй -Моно фракц ялгах тохиолдолд 15 кг хүртэл байж болно
		Бутлагдсан дээж	1 /нэг дээжийн жин/	
	Гидрогеологийн суурь судалгаа, шинжилгээний зориулалттай хөрс, усны дээж (сорьц)	Хөрсний болон гүний ус	1 л /нэг дээжийн хэмжээ/	Шинжилгээ хийлгэхээр гэрээ байгуулсан лабораториос тогтоосон дээжийн жинг үндэслэн өөрчлөлт оруулж болно
2	Хагас үнэт чулуу	Сорьц тогтоох болон туршилт, шинжилгээ хийх	1 хүртэл /Нийт дээжийн жин	Харилцан тохирсон гэрээ, сорьцын баталгааг үндэслэнэ
	Гоёл чимэглэлийн чулуу		3 хүртэл /Нийт дээжийн жин/	
	Өнгөлгөөний чулуу		100 хүртэл /Нийт дээжийн жин/	
3	Гадаад улс оронд зохиогдох үзэсгэлэн, хурал, эрдэм шинжилгээний материалд хавсралтаар ашиглагдаад буцаж ирэх чулуулаг, эрдэс бодис, үзмэрүүд тэдгээрийн электрон файл, геологийн болон бусад холбогдох фото зураг хавсралтууд	Чулуулаг, эрдэс бодис, үзмэр болон зураг, бичвэр, электрон файл		Буцааж авчрах гэрээг үндэслэнэ
4	Геологийн судалгааны ажлын үр дүнд боловсруулалт хийх зорилгоор гаргаж буй геологийн судалгааны мэдээлэл, зураг схемүүд	Зураг, бичвэр, электрон файл		Нууцлалын зэрэгтэй бичиг баримтад хамаарахгүй
5	Геологийн бусад салбар шинжлэх ухаан (Геогамшиг, геоэкологи гэх мэт)-ы судалгаа, шинжилгээний дээж (сорьц)	Хөрс, Эрдэс, чулуулаг		Шинжилгээ хийлгэхээр гэрээ байгуулсан лабораториос тогтоосон дээж (сорьц)-ийн жинг үндэслэнэ

Гурав: Хил нэвтрүүлэх тодорхойлолт олгох

- 3.1. Олон улсын болон дотоодын судлаачдын хамтарсан судалгааны ажилтай холбоотой цуглуулагдсан шинжилгээний зориулалттай дээж (сорьц)-ийг улсын хилээр нэвтрүүлэх тохиолдолд судалгааны ажлын тухай Үндэсний Геологийн албанд урьдчилан бүртгүүлж, мэдээлэл солилцсон байна.

- 3.2. Тодорхойлолт нь Үндэсний Геологийн Албаны тухайн чиглэлийн асуудал хариуцсан /нэгжийн/ дарга хянаж, шалгаж, албан ёсны бланкан дээр бичиж, дэд дарга буюу ерөнхий геологичийн гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 3.3. Энэ зааврын 1.4-т заасан этгээд улсын хилээр дээж (сорьц) нэвтрүүлэх зөвшөөрөл /тодорхойлолт/ хүссэн өргөдлийг батлагдсан маягтын дагуу Үндэсний Геологийн Албанд гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:
- Улсын хилээр дээж (сорьц) нэвтрүүлэх зөвшөөрөл /тодорхойлолт/ хүссэн тухайн байгууллагын албан бичиг,
 - Хилээр дээж (сорьц) нэвтрүүлэх үндэслэл / гадаад болон дотоод харилцагч байгууллага, лабораторитой хийсэн гэрээ, протокол, албан факс, захидал г.м/,
 - Гадаад хэл дээр үйлдэгдсэн гэрээ болон бусад материал нь баталгаат орчуулгатай байна /Монгол хэлээр/,
 - Түр зааварт тусгасан Маягт 1, Маягт 2 /тус бүр 1 хувь/,
 - Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн болон гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар,
 - Геологийн судалгаа, шинжилгээний итгэмжлэгдсэн лабораторид хяналт шалгалтын шинжилгээ хийлгэсэн тохиолдолд холбогдох баримт /шинжилгээний хариу/.
- 3.4. Энэ зааврын 3.3-т заасан материалыг хянаж, шаардлагыг хангасан нөхцөлд зөвшөөрөл /тодорхойлолт/ олгоно.
- 3.5. Үндэсний Геологийн Алба дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Хилээр нэвтрүүлэх дээжийн гарал үүсэл, төрөл, судалгаа шинжилгээнд явуулах үндэслэл бодитой эсэхийг мэргэжлийн зүгээс хянана,
 - Судалгаа, шинжилгээнд явуулахаар тусгайлан бэлтгэсэн дээж (сорьц)-ийг маягтад бичсэн тодорхойлолтын дагуу хянана,
 - Шаардлагатай гэж үзвэл тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн нь холбогдох бусад байгууллагын төлөөллийн хамт /төрийн захиргааны байгууллагын/ тухайн дээж (сорьц)-ийг бэлтгэсэн, ачиж, савласан талбайд биечлэн очиж шалгана,
 - Энэхүү зааварт заасан шаардлагад нийцээгүй болон хилээр нэвтрүүлэхийг хориглосон дээж (сорьц)-д зөвшөөрөл /тодорхойлолт/ олгохгүй.
- 3.6. Хилээр нэвтрэх дээж (сорьц)-ийн зөвшөөрөл /тодорхойлолт/-ийг олгохдоо албан бичгээр гаргасан хүсэлтийг хүлээн авснаас хойш ирүүлсэн материалын бүрдэл нь энэхүү журмын шаардлагыг хангасан тохиолдолд ажлын арван өдөрт багтаан шийдвэрлэнэ.
- 3.7. Олон улсын болон дотоодын судлаачдын хамтарсан судалгааны ажилтай холбоотой улсын хилээр нэвтэрсэн дээж (сорьц)-ийн судалгаа, шинжилгээний үр дүн нийтэд ил болмогц Үндэсний Геологийн Албанд албан ёсоор мэдээлнэ.



Маягт 1


Гаалийн ерөнхий газрын харьяа
..... гаалийн хороо /газарт/

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ОНЦЛОГ БАРААНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хилээр нэвтрүүлэх шинжилгээний дээж (сорьц)-ийн тодорхойлолт

1	Тодорхойлолт авч буй аж ахуйн нэгж, байгууллага, / хувь хүний овог, нэр, / хаяг, регистр, утасны дугаар	
2	Гаалийн хилээр нэвтрүүлэх үндэслэл болох баримт түүний дугаар /гэрээ, протокол, г.м/	
3	Барааны нэр, төрөл, тоо хэмжээ /ном, хэвлэлийн хуудасны тоо, хэмжээ/ үнэ	
4	Барааны код	
5	Нэвтрүүлж буй зорилго, хугацаа	
6	Хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн төрөл, боомтын нэр	
7	Нэвтрүүлэх он, сар, өдөр	
8	Хилээр нэвтрүүлэх хувь хүн, шуудан холбоо, тээврийн хэрэгслийн төрөл боомтын нэр	
9	Хүлээн авагчийн хаяг, утас, факс	

Эдгээр дээж (сорьц)-д гаалийн зохих хяналт хийж, хил нэвтрүүлэхийг зөвшөөрнө.



Маягт 2

Улсын хилээр нэвтрэх дээж (сорьц)-ийн жагсаалт

№	Дээж (сорьц)-ийн дугаар	Дээж (сорьц)-ийн тодорхойлолт	Дээж (сорьц)-ийн жин /кг/	Дээж (сорьц) авсан газар /орон зайн байршил, координат/	Шинжилгээний төрөл
Дүн					